



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/135

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг нэгдүгээр, “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Зааврыг мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн хичээлийн хөтөлбөрт тусгаж ажиллахыг Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн захирал (хурандаа Х.Сүхбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга (хурандаа Ж.Чүлтэмсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ ГАРИУНБУЯН



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
1/135 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАКТИК, ТАРХАЛТЫН ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө нь гал түймэр унтраах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах дадлага, сургалт зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.

1.3. Гал түймэр унтраах тактикийн дадлага, сургалтын төлөвлөгөөг Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөөг салааны захирагч боловсруулна.

1.4. Гал түймэр унтраах тактикийн дадлага, сургалтын төлөвлөгөөг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн орлогч нар хянаж, Онцгой байдлын газар, хэлтсийн дарга баталж, тухайн байгууллагын удирдлага зөвшөөрсөн байна.

1.5. Гал түймэр унтраах тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөөг Гал түймрийн улсын хяналтын байцаагч /ахлах/ хянаж, Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч батална.

1.6. Албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, стандарт, зааврын дагуу А4 хэмжээтэй үсгийн өндөр 12, Агил үсгийн фронт, хуудасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд болон доод захаас 20 мм зайтай, үндсэн бичвэрийг хуудасны хоёр талд зэрэгцүүлэн мөр хоорондын зай 1.15 мм, догол мөр хоорондын зай нь догол мөрөөс эхлэх хэсэг бүрийн өмнө брт хэмжээтэй боловсруулж, Монгол хэлний зөв бичих дүрмийг баримтална.

Хоёр. Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц

1. Дадлага, сургалтын удирдамж
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
3. Байгууллагын танилцуулга
4. Ажлын зураг
5. Гал түймэр унтраах хүч хэрэгслийн тооцоо
6. Гал түймэр унтраах хүн, хүч хэрэгслийг байрлуулсан зураг
7. Гал түймэр унтраах онцлог
8. Хүч нэмэгдүүлсэн дуудлагаар ажиллах хуваарь
9. Түр цугларах талбай, аварсан хүн, эд хөрөнгийг байрлуулах газар
10. Үнэлгээ, дүгнэлт
11. Материалжуулалт

2.1. Удирдамж хэсэгт: Дадлага, сургалт зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулж Онцгой байдлын газар, хэлтсийн дарга болон хамтран ажиллах байгууллагын удирдлагаар батлуулсан байна.

Удирдамжид дадлага, сургалтын зорилго, хамрах хүрээ, хугацаа, хүрэх үр дүн, хариуцах нэгж, албан тушаалтан, зохион байгуулах танхимын болон дадлага,

сургалтын хөтөлбөр, үнэлэх, дүгнэх, тайлагнах талаар тодорхой тусгаж, дадлага, сургалтын цагийн байдал, хүч хэрэгслийн болон зардлын тооцоо зэргийг хавсралтаар батлуулна.

2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэсэгт: Дадлага, сургалтад оролцох томилгоот бүрэлдэхүүний овог, нэр, албан тушаалыг хүснэгтээр гаргаж, гүйцэтгэх үүргийг танилцуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгсөн гарын үсэг зуруулан баталгаажуулсан байна.

2.3. Байгууллагын танилцуулга хэсэгт:

- Байгууллагын танилцуулга */үйл ажиллагааны чиглэл, ашиглалтад орсон огноо, ажиллагсадын тоо, аюулт үзэгдэл ослын үеийн удирдлага, гал түймрийн эрсдэл зэргийг товч тодорхой тусгана/*

- Хаяг байршил. Объектын үндсэн хаягийг тусгахаас гадна заргэлдээх томоохон хэмжээний объектуудыг тодорхой тусгана. (Мөн орчин үеийн дэвшилтэт технологи "what3words" гэх мэт байршил тогтоогч программ ашиглаж болно).

- Барилга, байгууламжийн онцлог. Дараах хүснэгтийн дагуу тусгасан байна.

№	Асуулга	Тайлбар
Барилгын материал		
1	Барилгын материалын шатдаг ангилал /БНБД 21-01-02/	
2	Барилгын материалын дөллөж авалцан асах чанар /БНБД 21-01-02/	
3	Гадаргуу дээрх дөлний тархалтын шинж чанар /БНБД 21-01-02/	
4	Шатамхай барилгын материалын утаа үүсэх чадвар /БНБД 21-01-02/	
5	Шатахдаа хортой бодис ялгаруулдаг шинж чанар /БНБД 21-01-02/	
Барилгын бүтээц		
1	Барилгын гал тэсвэршилтийн зэрэг /БНБД 21-01-02/	
2	Барилгын бүтээцийн галын аюулын анги /БНБД 21-01-02/	
3	Галын аюулын анги /БНБД 21-01-02/	
4	Галаас хамгаалах хаалт /БНБД 21-01-02/	
5	Шатын хонгилын төрөл /БНБД 21-01-02/	
6	Аврах гарц /БНБД 21-01-02/	
Бусад		
1	Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	
2	Дээврийн хөндийн талбайн хэмжээ	
3	Тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодисын нөөц хадгалалт	
4	Үйлдвэрлэлийн технологийн онцлог	
5	Өргөтгөлийн мэдээлэл	
6	Өдөр шөнийн цагаар ажиллаж байгаа ажилчдын тоо	
7	Аварсан эд хөрөнгийг байрлуулах талбай	
8	Усан хангамж	

2.4. Ажлын зураг хэсэгт:

- Гал түймэр унтраах, аврах ангиас объект хүртэлх маршрут *Igoogle earth, тар, зэргийг ашиглан хамгийн дөт замаар болон тухайн дөт зам хаагдсан гэж тооцож нөөц хүрэлцэн очих маршрут*, гадна усан хангамжийн байршил, объект хүртэл зай, тоо, техникийн үзүүлэлт, ажлын даралт зэргийг тусгана.

- Ерөнхий төлөвлөгөөний зураг. Тухайн объектын зэргэлдээх томоохон хэмжээний барилга байгууламж, зам гарцыг тусгана.

- Барилга байгууламжийн давхаруудын зохион байгуулалтын болон аврах зам гарцын байршил түүний урсгал чиглэл, дотор усан хангамжийн байршил, тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, цацраг идэвхт бодисын хадгалалт, халаалтын зуух, ус, уурын бойлерийн өрөө зэргийг тусгана.

- Цахилгааны төв шитний байршил

2.5. Гал түймэр унтраах хүч хэрэгслийн тооцоо хэсэгт:

1. Чөлөөт шатлагын хугацаа
2. Шатлагад өртсөн талбай
3. Унтраах талбай
4. Гал түймэр унтраахад шаардагдах бодисын хэмжээ, зарцуулалт
5. Хамгаалалтад ашиглах бодисын зарцуулалт
6. Бодит зарцуулалт
7. Нийт зарцуулалт
8. Гал түймэр унтраах хушууны тоо
9. Хамгаалалтад шаардагдах хушууны тоо
10. Хөөсний хушууны тоог тодорхойлох
11. Хөөс үүсгэгчийн хэмжээг тодорхойлох
12. Гал түймэр унтраах тасгийн тоо
13. Хамгаалалтад шаардагдах тасгийн тоо
14. Нийт тасгийн тоо
15. Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажлалх хугацаа

2.6. Гал түймэр унтраах хүн, хүч хэрэгслийг байрлуулсан зураг хэсэгт:

- Гал түймэр унтраах хүч хэрэгслийг байрлуулсан ажлын зургийг боловсруулсан албан тушаалтан Онцгой байдлын газар, хэлтсийн даргаар хянуулж батлуулсан байна.

- Онцгой байдлын албаны томъёолсон тэмдэг тэмдэглэгээг ашиглаж зургийг үйлдэнэ.

2.7. Гал түймэр унтраах онцлог хэсэгт: Байгууллагын үйл ажиллагааны онцлог, цаг агаарын нөхцөл байдал зэргийг үнэлэн Гал түймэр унтраах дүрэмд заагдсан гал түймэр унтраах онцлогийг сонгоно.

2.8. Хүч нэмэгдүүлсэн дуудлагаар ажиллах хуваарь хэсэгт:

Тухайн төв, орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа нийт гал түймэр унтраах, аврах ангиудын нэмэлт дуудлагаар гарах дараалал, хүн, хүч хэрэгслийн тооцоо судалгааг гаргах. Шаардлагатай тохиолдолд зэргэлдээх аймаг, орон нутгийн */дүүргийн/* хүн, хүч хэрэгслийг тооцох.

Орон нутгийн ус сувгийн болон ус тээвэрлэх боломжтой автомашин, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, бүлгийн судалгаа, холбогдох мэдээллийг тусгасан байна.

2.9. Түр цугларах талбай хэсэгт:

Түр цугларах талбайд цугларах талбай, аварсан хүн, эд хөрөнгийг байрлуулах газар, тухайн байгууллагын ажилчдын нэрсийг хүснэгтээр гаргаж, аюулгүй талбайн байршлын зургийг хавсаргана.

2.10. Үнэлгээ, дүгнэлт хэсэгт:

Онцгой байдлын байгууллага болон хамтран ажилласан бусад байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа, гүйцэтгэсэн үүрэг, ололт, дутагдал, санал дүгнэлт зэргийг дэлгэрэнгүй тусгана.

Сургалт, дадлагын үнэлгээ дүгнэлтэд үндэслэн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

2.11. Материалжуулалтын хэсэгт: Дадлага, сургалтын явцыг гэрэл зураг, видео бичлэгээр баримтжуулан хавсаргана.

Дадлага, сургалт зохион байгуулсан тухай илтгэх хуудас, тэмдэглэл бичиж дадлага, сургалтын материалын хамт цахимаар болон цаасаар архивлана.

Гурав. Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйлс

3.1. Дадлага, сургалтын төлөвлөгөө боловсруулахдаа тухайн орон нутгийн болон аж ахуйн нэгж байгууллагын нарийвчилсан үнэлгээтэй уялдуулан дадлага, сургалт зохион байгуулагдах байгууллагын удирдлага, албан тушаалтануудтай зөвшилцөн харилцан мэдээлэл солилцож боловсруулах.

3.2. Хэд хэдэн байгууллага хамтран сургууль зохион байгуулах тохиолдолд урьдчилсан уулзалтыг зохион байгуулж, удирдамж, хөтөлбөр, ажил үүргийн хуваарийг танилцуулж хамтран мэдээлэл солилцох.

Font: Ariel12

2см

Онцгой байдлын газрын
Гал түймэр унтраах, аврах 51 дүгээр анги

3см

1.5см

4см



3.5см

Font: Arial20

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАКТИК, ТАРХАЛТЫН ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Архангай аймаг 2021 он

ЗӨВШӨӨРӨВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА

2021 оны 01-р сарын-ны өдөр

БАТЛАВ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА

2021 оны 01-р сарын-ны өдөр

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАКТИКИЙН ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сэдэв: Эрүүл мэндийн газрын 2 дугаар давхарт гарсан гал түймрийг унтраах.

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр /60 минут/

Байршил: Эрдэнэбулган сумын Баян 2 дугаар баг, 3 дугаар хороо, Цэцэрлэгийн өргөн чөлөө 01 тоот, Эрүүл мэндийн газрын байр.

Гал түймэр унтраах, аврах 51-р ангиас – 3 км
..... ангиас – 2 км

Хянасан: Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга,

Боловсруулсан: Гал түймэр унтраах, аврах дүгээр ангийн захирагч,
.....

Шаардлагатай утасны дугаар: /Дарга /
/Менежер /
/Цахилгаанчин /
/Жижүүр /

ЗӨВШӨӨРӨВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА

БАТЛАВ
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ
... АНГИЙН ЗАХИРАГЧ

2021 оны 01-р сарын-ны өдөр

2021 оны 01-р сарын-ны өдөр

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ТАРХАЛТЫН ДАДЛАГА, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сэдэв: Эрүүл мэндийн газрын 2 дугаар давхарт гарсан гал түймрийг унтраах.

Хугацаа: 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр /60 минут/

Байршил: Эрдэнэбулган сумын Баян 2 дугаар баг, 3 дугаар хороо, Цэцэрлэгийн өргөн чөлөө 01 тоот, Эрүүл мэндийн газрын байр.


Гал түймэр унтраах, аврах 51-р ангиас – 3 км
..... ангиас – 2 км

Хянасан: Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Боловсруулсан: Гал түймэр унтраах, аврах дүгээр ангийн салааны захирагч,
.....

Шаардлагатай утасны дугаар: /Дарга /
/Менежер /
/Цахилгаанчин /
/Жижүүр /

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 16 дугаар сарын 14-ны өдрийн
А/125 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ШУУРХАЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, КАРТ БОЛОВСРУУЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт нь /цаашид ГТУШТ, ГТУШК гэх/ гал түймрийн нөхцөл байдлыг үнэн, зөв тодорхойлох, шийдвэрлэх чиглэлийг тогтоож, хүч хэрэгслийг цаг алдалгүй төвлөрүүлэн байрлуулах, гал түймэр унтраах аврах анги, гал сөнөөгч, аврагчдын харилцан ажиллагааг удирдан зохион байгуулах, томилгоот бүрэлдэхүүний гал түймэр унтраах тактикийн сэтгэлгээ, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гал унтраах удирдагчийг шаардлагатай мэдээллээр хангах шуурхай удирдлагын баримт бичиг байна.

1.3. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, картыг салааны захирагч боловсруулна.

1.4. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, картыг Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч баталж албажуулан хоёроос доошгүй хувь үйлдэж тухайн иргэн, хуулийн этгээдэд хүргүүлэн гал түймэр унтраах үйл ажиллагаанд ашиглана.

1.5. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулахдаа гал түймэр унтраах, аврах ангийн салааны захирагч нарыг татан оролцуулж гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.

1.6. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг 1-3 хүний бүрэлдэхүүнтэй аж ахуйн нэгж байгууллагад боловсруулж танхимаар сургалтыг зохион байгуулж болно.

1.7. Албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, стандарт, зааврын дагуу А4 хэмжээтэй үсгийн өндөр 12, Arial үсгийн фонт, хуудасны зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм, дээд болон доод захаас 20 мм зайтай, үндсэн бичвэрийг хуудасны хоёр талд зэрэгцүүлэн мөр хоорондын зай 1.15, догол мөр хоорондын зай нь догол мөрөөс эхлэх хэсэг бүрийн өмнө брт хэмжээтэй боловсруулж, Монгол хэлний зөв бичих дүрмийг баримтална.

1.8. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, картыг цахимаар болон цаасаар боловсруулж гал түймэр унтраах үйл ажиллагаанд ашиглана.

Хоёр. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөний бүтэц

2.1. Барилга байгууламжийн танилцуулга хэсэгт:

- Байгууллагын танилцуулга /үйл ажиллагааны чиглэл, ашиглалтад орсон огноо, ажиллагсадын тоо, аюулт үзэгдэл ослын үеийн удирдлага, гал түймрийн эрсдэл зэргийг товч тодорхой тусгана/

- Хаяг байршил. Объектын үндсэн хаягийг тусгахаас гадна заргэлдээх томоохон хэмжээний объект зэргийг тодорхой тусгана. (Мөн орчин үеийн дэвшилтэт технологи "what3words" гэх мэт байршил тогтоогч программ ашиглаж болно).

- Барилга, байгууламжийн онцлог хэсэгт дараах мэдээллийг тусгасан байна.

Үүнд:

№	Асуулга	Тайлбар
Барилгын материал		
1	Барилгын материалын шатдаг ангилал /БНБД 21-01-02/	
2	Барилгын материалын дөллөж авалцан асах чанар /БНБД 21-01-02/	
3	Гадаргуу дээрх дөлний тархалтын шинж чанар /БНБД 21-01-02/	
4	Шатамхай барилгын материалын утаа үүсэх чадвар /БНБД 21-01-02/	
5	Шатахдаа хортой бодис ялгаруулдаг шинж чанар /БНБД 21-01-02/	
Барилгын бүтээц		
1	Барилгын гал тэсвэршилтийн зэрэг /БНБД 21-01-02/	
2	Барилгын бүтээцийн галын аюулын анги /БНБД 21-01-02/	
3	Галын аюулын анги /БНБД 21-01-02/	
4	Галаас хамгаалах хаалт /БНБД 21-01-02/	
5	Шатын хонгилын төрөл /БНБД 21-01-02/	
6	Аврах гарц /БНБД 21-01-02/	
Бусад		
1	Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	
2	Дээврийн хөндийн талбайн хэмжээ	
3	Тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодисын нөөц хадгалалт	
4	Үйлдвэрлэлийн технологийн онцлог	
5	Өргөтгөлийн мэдээлэл	
6	Өдөр шөнийн цагаар ажиллаж байгаа ажилчдын тоо	
7	Аварсан эд хөрөнгийг байрлуулах талбай	
8	Дотор усан хангамж	

- Зэргэлдээх барилга байгууламжийн онцлог хэсэгт дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны чиглэл
- Барилгын хийц, бүтээц
- Тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодисын ашиглалт, нөөц хадгалалт,
- Усан хангамж

2.2. Ажлын зураг хэсэгт:

- Гал түймэр унтраах, аврах ангиас объект хүртэлх маршрут /*google earth, map, зэргийг ашиглан хамгийн дөт замаар болон тухайн дөт зам хаагдсан гэж тооцож нөөц хүрэлцэн очих маршрут*/, гадна усан хангамжийн байршил, объект хүртэл зай, тоо, техникийн үзүүлэлт, ажлын даралт зэргийг тусгана.

- Ерөнхий төлөвлөгөөний зураг. Тухайн объектын зэргэлдээх томоохон хэмжээний барилга байгууламж, зам гарцыг тусгана.

- Барилга байгууламжийн давхаруудын зохион байгуулалтын болон аврах зам гарцын байршил түүний урсгал чиглэл, дотор усан хангамжийн байршил,

хүчин чадал, тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, цацраг идэвхт бодисын хадгалалт, халаалтын зуух, ус, уурын бойлерийн өрөө зэргийг тусгана.

- Цахилгааны төв шитний байршил

2.3. Гал түймэр унтраах, аврах ангийн дуудлагаар ажиллах хуваарь хэсэгт:

Төв, орон нутагт үүрэг гүйцэтгэж байгаа гал түймэр унтраах, аврах ангиудын анхны дуудлагаар болон хүч нэмэгдүүлсэн 1, 2, 3 дагаар дуудлагаар ажиллах дараалал, хүн, хүч хэрэгслийн тооцоо, судалгааг тусгах. Шаардлагатай тохиолдолд зэргэлдээх аймаг, орон нутгийн /дүүргийн/ хүн, хүч хэрэгслийг тооцох.

Орон нутгийн ус сувгийн болон ус тээвэрлэх боломжтой автомашины судалгаа, холбогдох мэдээллийг тусгасан байна.

2.4. Түр цугларах талбай хэсэгт:

Түр цугларах талбайд цугларах талбай, аварсан хүн, эд хөрөнгийг байрлуулах газар, тухайн байгууллагын ажилчдын нэрсийг хүснэгтээр гаргаж, аюулгүй талбайн байршлын зургийг хавсаргана.

2.5. Шуурхай хамтран ажиллах байгууллага хэсэгт:

Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааг зохион байгуулахад шуурхай хамтран ажиллах мэргэжлийн байгууллагын /цагдаа, эмнэлэг, ус суваг, томоохон аж ахуйн нэгж байгууллага гэх мэт/ холбогдох албан тушаалтны мэдээлэл болон гүйцэтгэх үүргийг товч тодорхой тусгасан байна.

2.6. Зөвлөмж хэсэгт:

Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөний зөвлөмж хэсэгт тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог хийц бүтээц, технологийн горим зэрэг гал түймэр унтраах, аврах үйл ажиллагаа явуулахад учирч болзошгүй хүндрэлийг урьдчилан тооцож зөвлөмжийг дараах байдлаар товч, тодорхой боловсруулна.

Гал түймэр унтраах удирдагчид өгөх зөвлөмж

1. Объектын онцлог, цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч, гал түймэр унтраах шийдвэрлэх чиглэлийг зөв тодорхойлон шаардагдах хүн хүч, хэрэгслийг тооцоолж гал түймэр унтраах үйл ажиллагааны арга тактикийг тогтоох. Хүмүүсийг аврах ажиллагааг байгаа хүн хүч, хэрэгслийг ашиглан нэн даруй зохион байгуулах. Тухайн объектын үйл ажиллагааны онцлог технологийн горим, гал түймэр унтраах үед гарах хүндрэл, ус болон гал түймэр унтраах бодистой урвалд орсноос гарах хүндрэл зэргийг урьдчилан тооцох.

2. Хайгуулын хэсгийг томилох, гал түймэр тархан дэлгэрэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд түүнийг таслан зогсоох арга зам, үйлдвэрлэлийн технологи түүний онцлог, хүн эрсдэх боломжит газар, тэсэрч дэлбэрэх бодисын байршлыг тогтоох, авралтын зам гарц, хүний амь бие, эд хөрөнгө аврах, аварсан хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх боломж, нэмэгдэл хүч хэрэгслийг байрлуулах газрыг сонгох.

3. Нэмэгдэл хүн хүч, хэрэгслийг нэгэн зэрэг дуудаж угтах ажлыг зохион байгуулах, Гал түймрийн нөхцөл байдлын өөрчлөлтөд байнгын хяналт тавьж, тухай бүр шийдвэр гаргах.

4. Гал түймэр унтраах аврах анги, хэсгүүдэд гал түймэр унтраах шийдвэр өгч, тэдгээрийн харилцан ажиллагааг зохион байгуулан, өгсөн үүрэг шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

5. Аврах, эрэн хайх ажиллагааг зохион байгуулж хайгуул хийх бүрэлдэхүүнийг томилох.

6. Офицер бүрэлдэхүүнээс аюулгүйн ажиллагааг хариуцсан албан тушаалтанг томилж, шаардлагатай гэж үзвэл эмнэлгийн яаралтай тусламжийг зохион байгуулах.

7. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд дайчлан оролцуулсан албадын хамтын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, төв орон нутгийн төр захиргааны байгууллага, объектын инженер техникийн ажилтнуудтай байнга холбоотой байж, гал түймэр унтраах шийдвэр гаргахдаа тухайн объектын онцлогыг харгалзан заавар журмыг мөрдөх.

8. Гал түймрийг унтрааж дууссаны дараа дахин хайгуул шалгалт хийж, хэргийн газрыг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд хүлээлгэн өгөх хүртэл хамгаалах ажлыг зохион байгуулан, анги, хэсгийн ажиллах хугацаа, буцах дэс дарааллыг сонгох гэх мэт.

Гал түймэр унтраах штабын даргад өгөх зөвлөмж

1. Гал унтраах хүч хэрэгслийг хуваарилах, гүйцэтгэх үүргийг тодрхойлох.
2. Гал түймэр унтраах явцад хайгуулын ажлыг тасралтгүй зохион байгуулах.
3. Гал унтраах хүч хэрэгслийн тооцоог гаргах.
4. Улирдлагыг бусад хэсгүүдтэй холбоо мэдээллийн хэрэгслээр хэрхэн хангах.

5. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн хэсэг, аюулгүйн хэсгийг ажиллуулах.

6. Гал түймэр унтраах, аврах ажиллагаа 4 цагаас дээш удаан хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд бие бүрэлдэхүүнийг хоолоор, хүйтний улиралд дулаан хувцас байраар хангах

7. Гал түймэр унтраах үед татан оролцуулсан мэргэжлийн албадын үйл ажиллагааг удирдлагаар хангах, хэв журам сахиулах, сайн дурын, туслах хүчний, эмнэлгийн алба гэх мэт.

Арын албаны даргад

1. Усан хангамжийн хайгуулыг зохион байгуулах, дамжуулан шахах, ердийн аргаар ус тээвэрлэх авто тээврийн хэрэгсэл, гал түймэр унтраах даралтын хоолой, хөөс үүсгэгчийн тооцоог гаргаж нөөцийг бэлтгэх, тээвэрлэх ажлыг зохион байгуулах.

2. Нэмэгдэлээр ирсэн Гал түймэр унтраах, аврах ангиудыг угтан усны эх үүсвэр дээр хуваарилан байрлуулах, гал түймэр унтраах бодис, техник хэрэгсэлээр тасралтгүй хангах.

3. Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, амьсгалын бие даасан төхөөрөмжийн дагалдах хэрэгслийн нөөц, шатах тослох материал, халуун хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хувцас бэлтгэх гэх мэт.

Гурав. Гал түймэр унтраах шуурхай картны бүтэц

Гал түймэр унтраах шуурхай картыг боловсруулахдаа тухайн байгууллагын мэдээлийг товч, тодорхой тусгаж, ашиглахад хялбар буюу бичгийн цаасны А5 хэмжээтэй ар, өвөргүй боловсруулж, гал түймэр унтраах үндсэн албаны автомашинд байрлуулан гал түймэр түймэр унтраах үйл ажиллагаанд ашиглана.

3.1. Барилга байгууламжийн танилцуулга. /картын өвөр хэсэгт/

- Хаяг байршил. Объектын үндсэн хаягийг тусгахаас гадна заргэлдээх томоохон хэмжээний объект зэргийг тодорхой тусгана. (Мөн орчин үеийн дэвшилтэт технологи "what3words" гэх мэт байршил тогтоогч программ ашиглаж болно).

- Барилга, байгууламжийн онцлог хэсэгт дараах мэдээллийг тусгасан байна.

Үүнд:

№	Асуулга	Тайлбар
Барилгын материал		
1	Барилгын материалын шатдаг ангилал /БНБД 21-01-02/	
2	Барилгын материалын дөллөж авалцан асах чанар /БНБД 21-01-02/	
3	Гадаргуу дээрх дөлний тархалтын шинж чанар /БНБД 21-01-02/	
4	Шатамхай барилгын материалын утаа үүсэх чадвар /БНБД 21-01-02/	
5	Шатахдаа хортой бодис ялгаруулдаг шинж чанар /БНБД 21-01-02/	
Барилгын бүтээц		
1	Барилгын гал тэсвэршилтийн зэрэг /БНБД 21-01-02/	
2	Барилгын бүтээцийн галын аюулын анги /БНБД 21-01-02/	
3	Галын аюулын анги /БНБД 21-01-02/	
4	Галаас хамгаалах хаалт /БНБД 21-01-02/	
5	Шатын хонгилын төрөл /БНБД 21-01-02/	
6	Аврах гарц /БНБД 21-01-02/	
Бусад		
1	Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/	
2	Дээврийн хөндийн талбайн хэмжээ	
3	Тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодисын нөөц хадгалалт	
4	Үйлдвэрлэлийн технологийн онцлог	
5	Өргөтгөлийн мэдээлэл	
6	Өдөр шөнийн цагаар ажиллаж байгаа ажилчдын тоо	
7	Аварсан эд хөрөнгийг байрлуулах талбай	
8	Дотор усан хангамж	

3.2. Шуурхай хамтран ажиллах байгууллага. /картын өвөр хэсэгт/

Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааг зохион байгуулахад шуурхай хамтран ажиллах мэргэжлийн байгууллагын /цагдаа, эмнэлэг, ус суваг, томоохон аж ахуйн нэгж байгууллага гэх мэт/ болон тухайн байгууллагын холбогдох албан тушаалтны утасны дугаар болон холбогдох мэдээллийг товч тодорхой тусгасан байна.

3.3. Ажлын зураг. /картын ар хэсэгт/

- Гал түймэр унтраах, аврах ангиас объект хүртэлх маршрут /google earth, тар, зэргийг ашиглан хамгийн дөт замаар болон тухайн дөт зам хаагдсан гэж тооцож нөөц хүрэлцэн очих маршрут/,

- Ерөнхий төлөвлөгөөний зураг. Тухайн объектын зэргэлдээх томоохон хэмжээний барилга байгууламж, зам гарцыг тусгана.

- Гадна усан хангамжийн байршил, объект хүртэл зай, тоо, техникийн үзүүлэлт зэргийг тусгана.

- Барилга байгууламжийн давхаруудын зохион байгуулалтын болон аврах зам гарцын байршил түүний урсгал чиглэл, дотор усан хангамж, галын дотуур крант, цахилгааны төв шитний байршил.

Font: Ariel12

Онцгой байдлын газрын
Гал түймэр унтраах, аврах 51 дүгээр анги

2см

3см

БАТЛАВ.
ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИЙН
ЗАХИРАГЧ

1.5см

2021 оны 01-р сарын-ны өдөр

4см



3.5см

Font: Ariel20

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ШУУРХАЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Объектын хаяг, байршил: Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Баян 2 дугаар баг, 3 дугаар хороо, Цэцэрлэгийн өргөн чөлөө 01 тоот, Эрүүл мэндийн газрын байр.

Гал түймэр унтраах, аврах 51-р ангиас – 3 км
..... ангиас – 2 км

Шаардлагатай утасны дугаар: /Дарга /
/Менежер /
/Жижүүр /

Цагдаагийн байгууллага: 7034101, 7034

Эмнэлэгийн байгууллага: 7034103, 7034

Цахилгаан дамжуулах сүлжээ: 7004

Ус суваг: 7011

Боловсруулсан: Гал түймэр унтраах, аврах 51 дүгээр салааны захирагч
дэслэгч Б.Бат

Архангай аймаг 2021 он